

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 7 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт:

Монгол Улсын Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн яам, БНСУ-ын Хөдөлмөрийн яам хоорондын ажиллах хүч солилцох тухай санамж бичгийг 2008 оны 7 сарын 28 ны өдрөөс 3 жилийн хугацаатайгаар сунгах асуудлыг шийдвэрлэв.

Японы ОУ-ын сургалтын байгууллага ЖИТКО-ийн төлөөлөгчдийг хүлээн авч Япон улсад дадлагажигч илгээх ажлыг боловсронгуй болгох, мэдээллийн сүлжээ бий болгох асуудлаар харилцан санал солилцож тохиролцов.

Худалдаан дахь аж үйлдвэрийн хяналтын тухайн 161, Эрүүл ахуйн хяналтын тухай 81 дүгээр конвенцүүдийг соёрхон батлуулах хуулийн төсөл, үзэл баримтлал, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци, үзэл баримтлалыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээ.

НХХ-ийн сайдын тушаалаар эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдийн нэг цагийн хөлсийг 5000, 3000 төгрөгөөр шинэчлэн тогтоов.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Жендэрийн тэгш байдлыг хангах тухай Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Ховд аймгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах байрны үйл ажиллагааг дэмжих, нийгмийн ажилтнуудыг чадавхижуулах зорилгоор Ховд аймгийн Цагдаагийн хэлтэстэй, Булган аймагт Хүчирхийллийн эсрэг Үндэсний төвийн салбар байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Хүчирхийллийн эсрэг Үндэсний төвтэй гэрээ байгууллаа.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын Турин дахь сургалтын төвд зохиогдсон семинарт оролцож, МУ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудлаар илтгэл тавьсан.

Хүүхэд эрхлэхийг хориглосон ажлын байрны жагсаалтыг эзэд, үйлдвэрчний эвлэл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн болон төрийн бус байгууллагуудаар хэлэлцүүлэх семинарыг зохион байгуулав.

Боловсролын салбарт:

2008-2009 оны хичээлийн жилээс 12 жилийн сургалтын 6 настай хүүхдэд хичээл заах 1700 багш нарт зориулсан сургалтыг бэлтгэгдсэн 35 сургагч багш нар 7 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн 21 аймаг, нийслэлд явуулж эхэллээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 347 дугаар тушаалаар Энэтхэг Улсад болох олон улсын биологийн 19 дүгээр олимпиадад 2 багш, 4 сурагч, Вьетнам Улсад болох физикийн 39 дүгээр олимпиадад 2 багш, 5 сурагч, Египит Улсад болох мэдээллийн технологийн олимпиадад 2 багш, 4 сурагчийг тус тус оролцуулахаар шийдвэрлэж, тэдний замын зардалд зориулж, 35.1 сая төгрөг олголоо.

Боловсролын тухай хуулийн 40.2, 40.3 дахь хэсгийг үндэслэн Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах анги, МСҮТ-ийн анхан шатны нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг дундаж нормативыг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 7 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлээ. Ингэхдээ статистик үзүүлэлтийг харгалзан бүлэг дүүргэлтийг өмнөх жилүүдээс 1-3 хүүхдээр бууруулж, сургуулийн ангилалд сумын бага сургуулийг нэмж, нормативыг оруулж тооцсоны гадна эмийн зардалд нэг хүүхдэд 2000 төгрөг зарцуулахаар, 6 настай хүүхдийг сургуульд элсүүлж буйтай холбогдуулан асрагч багшийн тоог 30 хүүхдэд 1 багш байхаар тусгасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өгсөн чиглэлийн дагуу Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилан Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого-“Боловсрол” Үндэсний хөтөлбөрийг боловсруулахаар хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг, дэд багуудыг байгуулан, хөтөлбөрийн үзэл баримтлалыг боловсрууллаа.

Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг нэмэгдүүлэх тухай асуудлыг Засгийн газрын 2008 оны 7 дугаар

сарын 16 хуралдаанаар хэлэлцүүлж, 2009 оны улсын төсвөөс төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийг санхүүжүүлэх зарим зардал болон сургалтын төлбөрийн тооцоог хянаж, судлах ажлын хэсгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, Сангийн сайдын хамтарсан тушаалаар байгуулан ажиллуулж, дүгнэлтээ 8 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр үүрэг болгосон.

Их монгол Улс байгуулагдсаны 802 жилийн ой, Ардын хувьсгалын 87 жилийн ой, Үндэсний их баяр наадмын урлаг, соёлын арга хэмжээг тусгай хөтөлбөрийн дагуу урлагийн тоглолт, төрийн хүндэтгэлийн концерт, ардын урлагийн тоглолт, цирк, уран зургийн үзэсгэлэн зэрэг 20 гаруй арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.

Засгийн газрын 7 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар Утга соёлын өвийн төвийг Соёлын өвийн төвд нэгтгэн ажиллуулах талаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлснээр Соёлын өвийн төв нь шинэ зохион байгуулалтаар ажиллах болж, урлагийн болоод утга соёлын өвийг хамгаалах нэгдсэн тогтолцоог буй болгосноороо чухал юм.

Ардын уламжлалт урлагийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголын үндэстэн ястнуудын язгуур урлагийн “Алтан өв” наадмыг Ховд аймагт 7 дугаар сарын 27-ны өдрөөс 5 хоногийн хугацаатай зохион байгууллаа.

Монгол Улсын тусгай сангийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 379 дүгээр тушаалаар “Шинжлэх хаан, технологийн сангийн дүрэм”-ийг баталлаа.

“Монгол Улсын шинжлэх ухааны 108 боть” цувралыг хэвлүүлэн гаргахаар эхний ээлжинд Монгол хэлний жишсэн судлал, Монгол хэлний харьцуулсан судлал, Хөрс судлал, Ой судлал зэрэг 36 ботийг бичиж, нийт 300 хувь хэвлүүлэх ажлыг эхлүүлж, энэ ажилд нийт 43.2 сая төгрөгийг зарцуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 363 дугаар тушаалаар шийдвэрлэлээ.

Эрүүл мэндийн салбарт:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр 2008 онд худалдан авсан тоног төхөөрөмж, Засгийн газрын нөөц хөрөнгөөр гар хөл, амны өвчний эмчилгээ, оношлогоонд зориулж Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ)-д нийлүүлэх тоног төхөөрөмж, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт олгох тоног төхөөрөмж, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар болон ХӨСҮТ-д нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодис, Япон улсын “Өвчний үндэс” төслийн хүрээнд буцалтгүй тусламжаар ирсэн 200 ш эмнэлгийн ор, Италийн АИФО төрийн бус байгууллагын санхүүжилтээр худалдан авсан сургалт үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, НҮБ-ын Хүүхдийн сангийн “Дархлаажуулалт” төслийн шугамаар ирсэн вакцины хөргөгч, хөргөгчийн гүйдэл тохируулагч, хэм заагуур, вакцин зөөврийн сав, ХӨСҮТ-ийн вакцин хадгалах хүйтэн өрөөний тоног төхөөрөмж, Япон улсын Засгийн газрын санхүүжилт, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгээр хэрэгжиж байгаа “Шувууны томуу болон хүний томуугийн цартахлаас сэргийлэх, тэмцэх мэдээлэл, сургалт сурталчилгаа” төслөөр ирүүлсэн компьютер, прожектор, “Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийн санхүүжилтээр худалдан авсан ХДХВ/ДОХ-ын халдвар илрүүлэх шинжилгээний оношлуурын хуваарийг тус тус баталж, хуваарилагдсан эмнэлгийн тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцины хүйтэн хэлхээний болон сургалт, сурталчилгааны тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн бүртгэлд авч, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг ХӨСҮТ, БГХӨСҮТ, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгав.

Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.2 дугаар заалтыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2008 оны 160 дугаар тушаалаар 2009 онд ашиглах рашаан сувиллын орны дээд хязгаарыг тогтоож, нийслэл, орон нутагт уг тушаалыг хэрэгжүүлж, үйл ажиллагааны чанар, үр ашгийг дээшлүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, улсын хэмжээний үйлчилгээтэй рашаан сувиллын дарга нарт үүрэг болголоо.

Азийн хөгжлийн банкны “Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийг сайжруулах, мэдээлэл харилцаа холбооны технологи нэвтрүүлэх” техник туслалцааны төслийн Удирдах хорооны 2008 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2008 оны 162 дугаар тушаалаар эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн

тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор боловсруулсан “Health-info 2.0” програмын эх кодыг Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвд хүлээлгэн өгөхийг зөвшөөрч, програмыг өөрийн үйл ажиллагаатай уялдуулан хэрэглэж эрүүл мэндийн салбарын бодлого, чиглэлд нийцүүлэн хөгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвд даалгав.

Улсын их баяр, наадмын үеэр эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах хяналт тавих зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2008 оны 163 дугаар тушаалаар Төв цэнгэлдэх хүрээлэн болон Хүй долоон худаг дахь морь барианы газарт түргэн тусламжийн цэг ажиллуулан эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай хүргэж хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Эрүүл мэндийн газар, Яаралтай тусламжийн төвд, баяр наадмын үеэр гарч болзошгүй нарны болон хоолны хордлого, гэмтэл осолд өртсөн хүмүүст үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний шуурхай, бэлэн байдлыг хангаж ажиллахыг бүх шатны эмнэлгийн байгууллагын захирал дарга нарт, гадаадын иргэд, зочид төлөөлөгчдөд үзүүлэх тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг ханган, зохицуулж ажиллахыг клиникийн 2 дугаар нэгдсэн эмнэлэгт, хөдөө орон нутгаас ирэх алсын дуудлаганд үйлчлэх эмч, алсын түргэний автомашины бэлэн байдал болон эмнэлгийн тусламж үйлчилгээний шуурхай байдал, чанар хүртээмжид хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийг удирдах газарт тус тус даалгав.

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 12.1.5 дахь заалтыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2008 оны 171 дүгээр тушаалаар 2008 оны 7 дугаар сарын 24-нөөс наймдугаар сарын 03-нд олимпийн бэлтгэл хангах зорилгоор “Тооното” жуулчны баазад нэгдсэн цугларалтад гарах үндэсний шигшээ багийн параолимпийн тамирчдын нэрсийг баталж, цугларалтын зардал 3.2 сая төгрөгийг төвлөрсөн арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн газарт зөвшөөрч, бэлтгэл цугларалтыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Биеийн тамир спортын улсын хороонд үүрэг болгов.

Гурав. Шуурхай мэдээлэл

Гар, хөл, амны халдварт өвчин энэ сарын 08-ны өдрөөс эхлэн бүртгэгдсэн бөгөөд 2008 оны 7 дугаар сарын 29 –ний өглөөний 9.00 цагийн байдлаар уг өвчний 2959 тохиолдол бүртгэгдэж, 73 өвчтөн эмнэлэгт, 602 хүн эмнэлгээс гарч, 230 хүн өрхийн эмчийн хяналтанд гэртээ байна. Өвчлөгсөдийн 1458 нь эрэгтэй, 1501 нь эмэгтэй, 1454/49.1%/ нь 2 хүртэлх насны, 2668 /90.2%/ нь 15 хүртэлх насны хүүхэд, 136/7.9%/ нь 20-иос дээш насны хүмүүс байна.Өвчлөл нийслэлийн бүх дүүрэг, Баян-Өлгийгөөс бусад бүх аймгуудад гараад байна. Нийт өвчлөлийн 1378 /46.6%/ нь нийслэлд, 1581 /53.4%/ нь аймаг орон нутагт гарсан байна.Энэ өвчний улмаас хүндэрч нас барсан тохиолдол одоогоор гараагүй байна.

2008 оны эхний 6 сард улсын хэмжээнд нийт 30555 эх амаржиж 30658 амьд хүүхэд төрж өнгөрсөн оныхоос төрсөн эхийн тоо 5349-өөр, амьд төрсөн хүүхдийн тоо 5404-өөр тус тус нэмэгдсэн байна. Энэ хугацаанд 10 эх эндсэний 4 нь Улаанбаатар хотод, аймгуудаас Баян-Өлгий, Баянхонгор, Өвөрхангай, Увс, Ховд Хэнтий аймагт тус бүр 1 эх эндсэн байна. Эхийн эндэгдэл өнгөрсөн оны мөн үеэс 100000 амьд төрөлтөнд 70,33-аар буурсан байна. (100000 амьд төрөлтөнд 32,62 байна)

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 648 тохиолдол гарч өмнөх оныхоос 151-ээр, 1000 амьд төрөлтөнд 1,4 пунктээр тус тус нэмэгдсэн, Өвөрхангай 61(44,9), Дорноговь 25(40.5), Архангай 33(33,5), Хэнтий 23(31.9), Баянхонгор 30(30.0), Говь-Алтай 20(29.4), Говьсүмбэр 4(27.4), Хөвсгөл 42(27.1) аймагт улсын дундаж /21,1/-аас өндөр байна.

1-5 хүртэлх насны 132 хүүхэд эндсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 9-өөр, амьд төрсөн 1000 хүүхдэд 25,4 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.8 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

2008 оны эхний 5 сард 21871 халдварт өвчин бүртгэгдсэн нь урьд оны мөн үеийнхээс 525 тохиолдлоор буурч 10000 хүн амд 83,8 ногдож байна.

Халдварт өвчний бүтцийн хувьд авч үзвэл зонхилон тохиолдох бэлгийн замын халдварт өвчин 32,9%, гэдэсний халдварт өвчнүүдээс вируст гепатит 25,9%, цусан суулга 3,2%, амьсгалын замын халдварт өвчнөөс сүрьеэ 10,9%, гахай хавдар 1.9%, салхин цэцэг 7,6%, шинээр гарсан гар, хөл, амны өвчин 6.7%-ийг тус тус эзэлж байна.

Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнүүдээс халдварт саа, сахуу, хөхүүл ханиад зэрэг өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.

Халдварт өвчний улмаас 85 хүн нас барснаас сүрьеэгээр 50, вируст гепатитээр 17, менингококкт халдвараар 8, төрөлхийн тэмбүү, салхин цэцэг, цусан суулгаар тус бүр 2, хүнсний гаралтай бактерт хордлого, ёлом, ХДХВ-ийн улмаас тус бүр нэг хүн нас барсан байна.

Санхүү, эдийн засгийн салбарт:

Монгол Улсын Засгийн газрын (2008 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн) хуралдаанд Сангийн сайд Үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын явцын тухай танилцуулга хийсэн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс 2008 оны эхний хагас жилийн байдлаар 23.8 хувийн, харин зургадугаар сард 1.9 хувьтай гарч үнэ тарифын өсөлт зургадугаар сараас харьцангуй саарч эхэлсэн байна. Гэвч зарим эрх бүхий байгууллагын шийдвэрээр цахилгаан, дулаан, шатахуун, төмөр замын тээврийн тарифыг 2008 оны 7 дугаар сарын 15-наас эхлэн нэмэгдүүлэх болсон байна.

Эрчим хүчний зохицуулах зөвлөл гурил, талх зэрэг хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрт цахилгаан, дулааны үнийн тарифын хөнгөлөлт үзүүлэхээр шийдвэрлэжээ. ОХУ газрын тосны бүтээгдэхүүнийхээ экспортын татварыг 2008 оны 8 дугаар сарын 1-нээс тонн тутамд 97.8 ам.доллар буюу 20 хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн байна. Жишиг үнийн тухайд “Атар” талхыг 580 төгрөгөөр, гурилын үнийг 780 төгрөгөөр буюу хуучин үнээр нь зарлах зүйтэй гэж үзсэн байна.

Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын (2008 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын 282 дугаар тогтоолыг гаргуулсан байна. Энэхүү тогтоолоор Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжүүлж бензин шатахууны нөөц хэлбэрээр байршуулах газрын тосны бүтээгдэхүүнийг худалдан авах, тээвэрлэх, хадгалах, худалдах, нөхөн бүрдүүлэх үйл ажиллагааг зохицуулах журам, Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2008 онд Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр улсын хэмжээнд бүрдүүлэх газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ байршлыг тус тус баталсан байна. Энэ тогтоолоор баталсан журмын дагуу 2008 оны 7, 8 дугаар сард багтаан газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй газрын тосны нөөцийн бүтээгдэхүүн хадгалах тухай гурвалсан гэрээ байгуулахыг Үйлдвэр, худалдааны сайд, Сангийн сайд нарт даалгасан байна.

2008 оны зургадугаар сарын 11-ний өдрөөс мөн оны долдугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд улсын хилээр импортолж байгаа болон дотоодын зах зээлд худалдан борлуулж буй автобензин, дизелийн түлшний онцгой албан татварыг тэг “0” хувь, нэмэгдсэн өртгийн албан татварыг “5” хувиар, 2008 оны долдугаар сарын 15-ны өдрөөс онцгой албан татварыг тэг “0” хувь, гаалийн ба нэмэгдсэн өртгийн албан татварыг тэг “0” хувь байхаар тогтоосон байна.

Газрын тосны бүтээгдэхүүний үнэ байнга өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан Засгийн газраас тодорхой арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлж байна. Үүнтэй уялдуулан газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг төрийн бодлогоор дэмжиж, хайгуул олборлолтын үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр гадаадаас мэргэжлийн ажиллах хүч авах нь зүйтэй гэж үзсэн байна.

Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн 2009 оны үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг нэмэгдүүлэх тухай Засгийн газрын (2008 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, 2009 оны улсын төсвөөс төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийг санхүүжүүлэх зарим зардал болон сургалтын төлбөрийн тооцоог хянаж судлах үүрэг бүхий ажлын хэсгийг Сангийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаалаар байгуулан ажиллуулж, санал, дүгнэлтийг 2008 оны 8 дугаар сарын 15-ны дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд нарт даалгасан байна. Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн 2009 оны төсвийн төсөлд үйл ажиллагааны тогтмол зардал, эрдэм шинжилгээний зардал, эд хогшил худалдаж авах зардал, хөрөнгө оруулалт, урсгал ба их

засвар, зарим хөнгөлөлт, тэтгэлэг, тэтгэмжийн зардал, багш нарын мэргэжил дээшлүүлэх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгах нь зүйтэй гэж үзсэн байна. Эдгээр арга хэмжээнд урьдчилсан байдлаар 14.2 тэрбум төгрөг зарцуулах тооцоо гарсан ажээ. Үүний дүнд төрийн өмчийн сургуулиудын сургалтын төлбөрийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн мөнгөний хэмжээг тодорхой хувиар бууруулах, оюутанд ногдох сургалтын төлбөрийн ачааллыг багасгах, өрх гэрийн төсөвт учруулах хүндрэл бэрхшээлийг нимгэлэх нэг нөхцөлийг бүрдүүлэх алхам хийгдэх юм.

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлэх “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл”-ийн тухай Засгийн газрын (2008 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, энэхүү төслийн хэлэлцээ явуулах зөвшөөрлийг Сангийн сайдад олгосон байна. Үүний дагуу “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл”-ийн хэлэлцээг 2008 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хийсэн.

Монгол Улсын Сангийн сайд, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Тагнуулын ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Авилгатай тэмцэх газрын даргын (2008 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 265;А/-84;Н/53;А/-16;МН/94;А/15 дугаар) хамтарсан тушаалаар Гүйцэтгэх ажлын урсгал зардал болон төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах журмыг баталж, мөрдүүлсэн байна. Энэхүү журам нь гүйцэтгэх ажлын урсгал зардлыг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах; төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах гэсэн хэсгээс бүрдэж байна.

Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын (2008 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 258/267/81 дүгээр) хамтарсан тушаалаар Төлбөр тооцооны үндэсний зөвлөлийн дүрмийг баталж, мөрдүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 270 дугаар тогтоолын 3 дугаар заалтыг үндэслэн Хуульзүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын (2008 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 170/271 дүгээр) хамтарсан тушаалаар Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журам, Төлбөрт үйлчилгээний үнийн жагсаалтыг баталж, мөрдүүлсэн байна. Энэхүү журам нь ерөнхий зүйл; төлбөртэй үзлэг, үйлчилгээний төрөл; төлбөр гаргуулах нөхцөл; төлбөрийн мөнгийг хураан төвлөрүүлэх, зарцуулах гэсэн хэсэгтэй бөгөөд нийт 21 төрлийн төлбөртэй үйлчилгээг амбулаториор хийгдэх үйлчилгээ, цогцост гүйцэтгэх шинжилгээ, үйлчилгээ, бусад үйлчилгээ гэж ангилан төлбөрийн хэмжээг тогтоосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 83 дугаар тогтоолын 3 дугаар заалтыг үндэслэн Сангийн сайд, Үйлдвэр, худалдааны сайдын (2008 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 289/82 дугаар) хамтарсан тушаалаар Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын үйл ажиллагааны чиглэлээр хөрөнгө оруулах тоног төхөөрөмжийн жагсаалтыг баталж, мөрдүүлсэн байна. Энэхүү жагсаалтад хөдөө аж ахуй, аж үйлдвэр, цахилгаан, хийн үйлдвэрлэл, нийтийн аж ухуй, барилга, аялал жуулчлалын барилга угсралт, эрүүл мэнд, биеийн тамир, боловсрол, шинжлэх ухаан, харилцаа холбоо, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр 178 төрлийн тоног төхөөрөмжийн нэрийг зөвшөөрсөн байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг боловсруулахтай холбогдуулан Монгол Улсын төсвийн хүрээний мэдэгдлийн тооцонд суурилан Макро эдийн засгийн болон нийгмийн салбарын 2009 оны суурь тооцоо, таамаглалыг гаргасан байна. Эдийн засгийн бодит өсөлт 2008 онд 10 орчим хувьтай, 2009 онд 11.1 хувьтай гарч, ДНБ-ий хэмжээ (оны үнээр) **6643** тэрбум төгрөгт хүрч нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2100 ам доллар болохоор байна. ДНБ-ий 2009 оны бодит өсөлтийг үндсэн салбараар судлан үзэхэд хөдөө аж ахуйн салбар 6.9 хувь, аж үйлдвэрийн салбар 11.4 хувь, үйлчилгээний салбар 14.0 хувиар өсөх төлөвтэй байна. Гадаад худалдаа, дэд бүтцийн салбар 2009 онд нэлээд өргөжиж, бүтээн байгуулалтын ажил өрнөснөөр эдийн засгийн өсөлтийг дэмжих хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх онуудаас эрс өсөх бололтой байна. Өмнөх онуудад хэрэгжүүлж ирсэн “Хүүхдийн мөнгө”, “Шинэ гэр бүл”, “Шинэ хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлэн нийгмийн хамгааллын болон өрх гэрийг дэмжсэн бодлогыг дэс дараатай явуулснаар ядуурлын хэмжээ 2009 онд өмнөх оноос буурах төлөв ажиглагдаж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2008 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тухай Засгийн газрын (2008 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн) хуралдаанд танилцуулсан байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2008 оны эхний зургаан сарын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргаж, мэдээлсэн байна. **Үүнд:**

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2008 оны эхний зургаан сарын гүйцэтгэлээр **1,033.2** тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөөг 16.0 тэрбум төгрөгөөр буюу 1.6 хувиар давуулан биелүүлж, 2007 оны мөн үеийнхээс 40.1 хувиар буюу 295.9 тэрбум төгрөгөөр илүү байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг эх үүсвэрээр нь задалж үзвэл татварын орлогоор 87.8 хувийг, татварын бус орлогоор 11.9 хувийг, хөрөнгийн ба тусламжийн орлогоор 0.3хувийг бүрдүүлсэн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлэхэд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 43.3 хувиар буюу 59.8 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 20.6 хувиар буюу 16.8 тэрбум төгрөгөөр давсан явдал гол нөлөө үзүүлжээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага 2008 оны эхний зургаан сарын төлөвлөгөөгөөр 1,451.2 тэрбум төгрөг (үүнээс: улсын төсвийн зарлага 1,098.0 тэрбум төгрөг) зарцуулахаас гүйцэтгэлээр **1,038.1** тэрбум төгрөг (улсын төсвийн зарлага 808.6 тэрбум төгрөг)-т хүрч, төлөвлөсөн нэгдсэн төсвийн зарлагын 71.5 хувийг (улсын төсвийн зарлагын 73.6 хувийг) санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн 2007 оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 378.6 тэрбум төгрөгөөр буюу 57.4 хувиар (улсын төсвийн зарлага 2007 оны мөн үеийнхээс 176.2 тэрбум төгрөгөөр буюу 27.9 хувиар) өссөн байна.

Нийт урсгал зардлын 10.6 хувийг буюу 109.8 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангийн зардал, 28.4 хувийг буюу 297.0 тэрбум төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, *өөрөөр хэлбэл*, нийт зардлын 39.0 хувийг буюу 406.8 тэрбум төгрөгийг цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зардалд зарцуулсан байна.

Орон нутаг 2008 оны эхний зургаадугаар сарын гүйцэтгэлээр төсвийн орлогын төлөвлөгөөг 12.1 хувиар буюу 11.3 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлж, төсвийн зарлагыг 94.4 хувиар буюу 5.3 тэрбум төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна. Улсын төсөвт орон нутгаас 23.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 22.8 тэрбум төгрөг оруулж, Сэлэнгэ аймаг төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг тасалсан байна.

Монгол Улсыг хөгжүүлэх санд 2008 оны эхний зургаан сард зарим бараа бүтээгдэхүүний албан татвараар **197.9** тэрбум төгрөг төвлөрүүлж, сангийн оны эхний үлдэгдлээс 0-18 насны хүүхэд бүрт олгох мөнгөн тэтгэмжид 44.0 тэрбум төгрөг; Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсвийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 34.7 тэрбум төгрөг (нийт **78.7** тэрбум төгрөг)-ийг зарцуулсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн (*өссөн дүнгээр*) 2008 оны эхний зургаан сарын буюу эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр урсгал тэнцэл **191.5** тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл **4.8** тэрбум төгрөгийн алдагдалтай (үүнээс: улсын төсвийн урсгал тэнцэл 24.6 тэрбум төгрөгийн, нийт тэнцэл 146.5 тэрбум төгрөгийн алдагдалтай) гарсан байна.

Улсын төсөвт байгууллагын 2008 оны эхний зургаан сарын төсвийн зарлагын гүйцэтгэлийн мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч нараар нэгтгэн гаргаж мэдээлэв. Улс, орон нутгийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын 2008 оны эхний хагас жилийн өглөг, авлагын мэдээг батлагдсан маягтын дагуу нэгтгэн гаргаж, ОУВС-д хүргүүлээ. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2008 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр (2008 оны долоодугаар сарын 1-ний үлдэгдэл) төсөвт байгууллагуудын төсвийн нийт авлага **6,108.8** сая төгрөгт хүрч, 2008 оны эхнээс 892.4 сая төгрөгөөр, төсвийн нийт өглөг **5,619.1** сая төгрөгт хүрч, 2008 оны эхнээс 1,198.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Төсвийн байгууллагын өр оны эхнээс 27.1 хувиар буюу 1.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд **нэгдүгээрт**, зах зээл дэх хэрэглээний барааны үнэ огцом өссөн; **хоёрдугаарт**, төсөвт байгууллагуудад 2007 оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг зарцуулах эрхийг олгоогүй явдал голлон нөлөөлсөн байна. Төсвийн төлөвлөгөөнд жилийн туршид инфляцийн дундажийг 6 хувь байхаар тооцсон боловч инфляцийн түвшин 2008 оны эхний зургаан сарын байдлаар **23.8** хувьд хүрсэн байна..

Батлагдсан төсвийн хуваарийн дагуу улс, орон нутгийн төсөвт байгууллагын 2008 оны гуравдугаар улирлын төсвийн урсгал зардлын эрхийг хянаж, 2008 оны долоодугаар сарын урсгал зардалд **36.4** тэрбум төгрөг нэмж гаргах замаар 2008 оны эхний долоон сарын байдлаар (өссөн дүнгээр) **824.9** тэрбум төгрөгийн санхүүжилт олгох арга хэмжээ авлаа. Тухайлбал, халамжийн тэтгэвэрт 33,171.6 сая төгрөг (тухайн сард 3,474.8 сая төгрөг), тэтгэврийн нөхөн олговорт 127.5 сая төгрөг (тухайн сард 13.9 сая төгрөг), тэтгэврийн даатгалын сангийн татааст 92.1 тэрбум (тухайн сард 13.0 тэрбум төгрөг) төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжид 19.9 тэрбум төгрөг (тухайн сард 2.8 тэрбум төгрөг), шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламжид 3,067.4 сая төгрөг (тухайн сард 381.5 сая төгрөг), шинэ гэр бүлийн мөнгөн тусламжид 9,955.8 сая төгрөг (тухайн сард 932.5 сая төгрөг), алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тэтгэмжид 8,451.8 сая төгрөг, түүнчлэн улс, орон нутгийн төсөвт байгууллагын урсгал төсвийн санхүүжилт зэрэгт 658.1 тэрбум төгрөгийг олгосон болно.

Монгол Улсыг хөгжүүлэх сан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан, Засгийн газрын нөөц сан, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хураангуй ба дэлгэрэнгүй тайланг нэгтгэн гаргаж, дүнг долоо хоног тутам удирдлагад тайлагнаж байна. Засгийн газрын шийдвэрийн дагуу 2008 оны эхний долоон сард Засгийн газрын нөөц сангаас 9,924.7 сая төгрөг (тухайн сард 2,251.6 сая төгрөг)-ийг зарцууллаа. Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангаас хүнс, хөдөө аж ахуйн зээлийн хүүгийн урамшуулалд 2008 оны эхний долоон сард 11,588.7 сая төгрөгийг хувь хүн ба аж ахуйн нэгж, байгууллагад олгосон байна. Засгийн газрын тогтоол, Сангийн сайд, Үйлдвэр, худалдааны сайдын хамтарсан тушаалын түлш шатахууны үнийн зөрүүд Эрсдлийн сангаас 3,504.4 сая төгрөгийг олгох арга хэмжээ авлаа. Түүнчлэн 2008 оны эхний долоон сард орон нутагт олгох НӨАТ-ын шилжүүлгээр 21,365.8 сая төгрөг (тухайн сард 3,781.9 сая төгрөг)-ийг, санхүүгийн дэмжлэгээр 17,290.4 сая төгрөг (тухайн сард 1,547.2 сая төгрөг)-ийг хуваарилан олгов.

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тусгай дансанд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвараар 2008 оны эхний зургаан сарын байдлаар **248.5** тэрбум төгрөгийг төвлөрүүлж, **94.9** тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны 8 дугаар сарын 1-ний үлдэгдэл **453.6** тэрбум төгрөг болсон байна:

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсвийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 50.9 тэрбум төгрөг (тухайн сард 16.2 тэрбум төгрөг), 0-18 насны хүүхэд бүрт олгох мөнгөн тэтгэмжид зориулан 44.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Улсын төсвийн 2008 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний батлагдсан хуваарь, түүний өөрчлөлтийг програм хангамжид байрлуулж, төсвийн санхүүжилт олгох боломжийг бүрдүүлсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2008 оны эхний зургаан сарын байдлаар нийтдээ **114.6** тэрбум төгрөг (тухайн сард 21.4 тэрбум төгрөг)-ийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Мөн батлагдсан хуваарийн дагуу 2008 оны эхний долоон сард **42,437.1** сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг орон нутгийн төрийн сангийн хөрөнгө оруулалтын дансанд хуваарилан олгосон байна.

Өрийн удирдлагын DMFAS-ийн мэдээллийн баазад 2008 оны эхний зургаан сарын байдлаар **25.0** тэрбум төгрөг (тухайн сард 6.4 тэрбум төгрөг)-ийн зээлийн ашиглалтын мэдээллийг оруулж, дүн мэдээг бүрэн тусгаж ажилласан байна. Засгийн газар 2008 оны эхний долоон сард гадаад зээлийн үндсэн төлбөрт 25,038.7 сая төгрөг (тухайн сард 1,117.5 сая төгрөг), хүүгийн төлбөрт 9,409.6 сая төгрөг (тухайн сард 520.9 сая төгрөг), нийт **34.4** тэрбум төгрөг төлсөн байна. Арилжааны банкуудаас дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 2008 оны эхний долоон сард зээлийн үндсэн төлбөрт 4,339.0 сая төгрөг (тухайн сард 441.2 сая төгрөг), хүүгийн төлбөрт 5,116.1 сая төгрөг (тухайн сард 507.4 сая төгрөг), нийт **9.46** тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны эхний долоон сарын өрийн бичиг, үнэт цаасны дэлгэрэнгүй тайланг гаргаж, дүнг төсвийн нэгдсэн мэдээнд тусгасны хамт Засгийн газрын бондын эхний долоон сарын үндсэн төлбөрт 21778.6 сая төгрөг, хүүгийн төлбөрт 922.2 сая төгрөг, бүгд **22.7** тэрбум төгрөг төлсөн байна. Одоогоор Засгийн газрын үнэт цаасны үлдэгдэл 2008 оны 8 дугаар сарын нэгний байдлаар **1,464.9** сая төгрөг байна.

Сангийн сайдын 2008 оны 269, 286 дугаар тушаалын дагуу Засгийн газрын үнэт цаасны 137, 138 дугаар арилжаагаар тус бүр 5.0 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий Засгийн газрын хямдруулсан үнэт цаасыг олон нийтэд санал болгон арилжаа зохион байгуулав. Засгийн газрын үнэт цаасны арилжаанд Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв оролцож, 29.8 сая төгрөгийн үнэт цаасыг худалдан авсан байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдэл 2008 оны эхнээс 275.5 тэрбумаар төгрөгөөр буурч, 2008 оны 8 дугаар сарын 1-ний байдлаар **39.1** тэрбум төгрөг болсон байна. Энэхүү төрийн сангийн мөнгөн хөрөнгийн сул чөлөөтэй эх үүсвэрээс Монголбанк, арилжааны банкуудад төгрөгийн ба валютын богино хугацаат хадгаламж байршуулж, 2008 оны эхний долоон сарын **3.6** тэрбум төгрөг (тухайн сард 100.0 сая төгрөг)-ийн хүүгийн орлого олсон байна. Монголбанкт мэдээлэл солилцох журмын хүрээнд төрийн сангийн нэгдсэн дансны зарлага санхүүжилт, орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг Монголбанкинд 7 хоног тутам мэдээлж байна.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцын эрхийг тулган шалгах ажлыг зохион байгуулж, Дундговь аймгийн төрийн санд орон нутгийн ба улсын төсвийн багцын хооронд буруу гүйлгээ хийгдсэнээс үүссэн зөрүүг арилгуулав. Сангийн сайдын тушаалаар баталсан удирдамжийн дагуу гадаад оронд суугаа манай улсын 15 элчин сайдын яамны 2006, 2007 оны болон 2008 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд шалгалт явуулж дууссан байна. Шалгалтаар нийт 491.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 6 төрлийн актаар 51.7 сая төгрөгийн торгууль, төлбөр тавьсан байна. Түүнчлэн 2007 оны төлөвлөгөөнөөс давсан орлого, төсвийн хэмнэлтийг буцаан зарцуулах эрхийг төсөвт байгууллагад зөвшөөрсөн хэмжээгээр нээж, улсын төсвийн дансанд **12.1** тэрбум төгрөгийн үлдэгдлийг татан төвлөрүүлсэн дүнтэй байна.

Сангийн сайдын (2008 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 295 дугаар) тушаалаар Засгийн газрын “Атрын гуравдахь аян”-тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн ашиглалтын байдал, зээлийн зориулалтын талаар иргэдээс ирүүлсэн санал гомдлыг хянан шалгах, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, түүний ажлын удирдамжийг баталж, шалгалтын ажлын дүнг 2008 оны 8 дугаар сарын 15-ны дотор нэгтгэн танилцуулахыг Төрийн сангийн газрын Өрийн удирдлагын хэлтэст даалгасан байна.

“Жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн олон улсын стандарт”-ын “Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр” гэсэн 11 дүгээр хэсэг, “Орлогын албан татвар” гэсэн 28 дугаар хэсэг, “Гадаад валютын хөрвүүлэлт” гэсэн 30 дугаар хэсэг, “Зогсоосон үйл ажиллагаа ба борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө” гэсэн 36 дугаар хэсэг, “Завсар үеийн санхүүгийн тайлагнал” гэсэн 37 дугаар хэсгийн орчуулгын 2 ба 3 дахь шатны хянан найруулгын ажлыг гүйцэтгэж дуусгасан байна.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн зөвлөлийн хурлыг (2008 оны 7 дугаар сарын 16-ны өдөр) зохион байгуулж, салбарын яамд болон арилжааны банкуудаас зээлийн хүүгийн төлбөрийн урамшуулал олгохоор шалгаруулж ирүүлсэн 24 аж ахуйн нэгж, иргэний төслийн жагсаалтыг хэлэлцэж, эдгээрийг зөвшөөрсөн шийдвэр гаргасан байна. Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн зөвлөлийн хурлын 8 дугаар шийдвэрийг үндэслэн Сангийн сайдын (2008 оны 7 дугаар сарын 23-ны өдөр 287 дугаар) тушаалаар 24 аж ахуйн нэгж, иргэдийн төслийн зээлийн хүүгийн урамшуулалд 1,927,548,156 төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн байна.

Азийн хөгжлийн банктай хамтран 2009-2010 онд хөдөө аж ахуй, хот байгуулалт, худалдааны хөнгөлөлт, эрүүл мэнд, боловсрол болон зам тээврийн салбарт зарим төсөл хэрэгжүүлэхээр тохиролцож, Харилцан ойлголцлын санамж бичгийг (2008 оны 7 дугаар сарын 7-ны өдөр) байгуулсан байна.

АНУ-ын улаанбуудайн тусламжийн 1999, 2000 оны хэлэлцээрийн үлдэгдэл хөрөнгийг Энхтайвны корпусын үйл ажиллагаанд зориулахаар тохиролцсоны үндсэн дээр хэлэлцээрт Сангийн сайд (2008 оны 7 дугаар сарын 14-ний өдөр) гарын үсэг зурсан.

Үйлдвэр, худалдааны салбарт:

“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсэд Мэргэжлийн албадын нэгдсэн байрыг барих ажлыг гүйцэтгэх сонгон шалгаруулалтын ээлжит хурлыг хийж “ДЕК” ХХК-ийг сонголоо.

Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолыг батлуулав. Ингэснээр газрын тосны нөөц бүрдүүлэх ажлыг журмын дагуу гүйцэтгэх, газрын тосны бүтээгдэхүүнд оногддог татварыг Засгийн газраас хөдөлгөх боломжтой болов.

“Ахуй үйлчилгээний хөтөлбөр”-ийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, импортын зарим нэгэн бүтээгдэхүүнийг Монгол шошготой болгох техникийн зохицуулалтын арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, тэмдэглэл гаргав.

“Зарагоза 2008 ЭКСПО” олон улсын үзэсгэлэнгийн нээлтийн ажиллагаанд оролцож, Монголын Павилионыг нээж ажиллуулж эхлэв.

Монгол Улс, АНУ хоорондын “Худалдаа хөрөнгө оруулалтын харилцааг хөгжүүлэх хэлэлцээр”-ийн хүрээнд “Монголын гар урлалын 14 төрлийн бүтээгдэхүүн гаргах гэрээ”-нд Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү гарын үсэг зурав.

Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын эдийн засгийн 2 дугаар Зөвлөлдөх Уулзалтын бэлтгэл ажлыг хангаж, ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, уулзалтын үеэр Монголын талаас тавих яамдуудын саналыг нэгтгэж, Гадаад хэргийн яаманд хүргүүлэв.

Швейцарь улсын Монтрео хотноо зохион байгуулсан НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр /UNDP/, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-аас хамтран зохион байгуулсан “Худалдааны тусламж”-ийн асуудлаарх уулзалтад оролцлоо. Энэхүү уулзалтаар хөгжиж байгаа орнуудад олгосон “Худалдааны тусламж”-ийг хянахад хандивлагч орнуудыг хэрхэн татан оролцуулах талаар 8-10 экспертийн түвшинд уулзалт, ярилцлага зохион байгуулав. Манай улсын хувьд УИХ-аас 2008 онд баталсан “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д үйлдвэр, худалдааны чиглэлээр тусгасан цогц бодлого, стратегийн зорилттой уялдуулан Засгийн газраас баримтлах “Худалдааны дунд хугацааны үзэл баримтлал”-ыг УИХ-аар батлуулж, хэрэгжүүлэх хөтөлбөрийг Засгийн газраар батлуулахаар ажиллаж байна. Энэхүү “Худалдааны дунд хугацааны үзэл баримтлал”-ыг хэрэгжүүлэх, хөтөлбөрийг санхүүжүүлэх асуудлаар ДХБ-ын “худалдааны тусламж”-ийг авахаар ажиллаж байна.

Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яам, ОХУ-ын “Росатом” корпорацийн хооронд байгуулсан ураны хүдэр эрж хайх, олборлох, боловсруулах салбарт хамтран ажиллах тухай Протоколыг хэрэгжүүлэх ажлын хэсгийн хуралдааны тов, хэлэлцэх асуудлаар санал бэлтгэж, оросын талд хүргүүлэв.

“Малчдаас монгол ямааны ноолуур худалдан авсан үндэсний үйлдвэрлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох журам”-ын дагуу аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах комисст ажиллав. Ноолуур худалдан авах эргэлтийн хөрөнгийн зээлэнд зориулан ХХБ-д байршуулсан 10 тэрбум төгрөгнөөс 6 тэрбум төгрөгийг “Говь” ХК-д олгохоор шийдвэрлэсэн. Бусад 3 компанийн холбогдох материалыг судлан ойрын хугацаанд шийдвэрлэхээр ажиллаж байна.

Эргэлтийн хөрөнгийн зээл олгохтой холбоотойгоор аймгуудаас ноолуур худалдаж авах компанийн хувиарлалтыг хийв. Засгийн газрын 260 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Худалдаа, хөгжлийн банк, Капитал банкттай хамтран ажиллах 3 талт санамж бичгийг байгуулав. Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн алтны үндсэн ордын хүдрийг баяжуулах үйл ажиллагааг 3-4 газарт төвлөрүүлэн зохион байгуулах асуудлын хүрээнд Төв аймгийн Борнуур суманд байгуулсан цэгийн ажлыг эхлүүлээд байна.

Байгаль орчны салбарт:

“Агнуурын загас хамгаалах үржүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, “Хот тосгоны төлөвлөлтөд ногоон байгууламжийн талбайн доод хэмжээг мөрдүүлэх тухай” Байгаль орчны сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан тушаалыг гаргав.

Ойг нөхөн сэргээх, ногоон хэрэмийн зурвас байгуулах ажлын хаврын тарилтын урьдчилсан гүйцэтгэлийг гаргахад Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийн хүрээнд ногоон зурвас байгуулах ажлыг 471 га, ойг нөхөн сэргээх ажлыг 8000 га-д хийгдсэн байна.

Архангай аймгийн Цэцэрлэг, Цахир, Тариат, Хангай, Булган, Төвшрүүлэх сумын ой зохион байгуулалтын хээрийн хайгуул судалгааны ажлыг 100 хувь, Чулуут, Жаргалант, Хотонт сумын ой зохион байгуулалтын хээрийн хайгуул судалгааны ажлын 40-70 хувийг тус тус гүйцэтгээд байна. Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлыг нийслэлийн ногоон бүс, Хөвсгөл, Булган, Архангай, Хэнтий, Төв, Увс, Завхан аймгуудын нутагт нийтдээ 58356 га талбайд явуулаад байна.

Ойн нөөцийг нөхөн сэргээх чиглэлээр санаачлага гаргасан зарим иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжиж тэдгээрийн оролцоог хангах зорилгоор 2008 онд улсын төсвийн хөрөнгөөр Таримал ойг хамгаалах нөхөн тарилт хийх, Мод үржүүлгийн газар тэдгээрт шаардагдах хөрөнгө батлах тухай Байгаль орчны сайдын тушаалуудыг тус тус гаргуулж, холбогдох аймгийн Байгаль орчны албатай гэрээ байгуулж байна.

Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны иргэдийн санал гомдлын дагуу Гачуурт тосгоны нутаг дэвсгэрт Туул голын татамд 50 га газар гольфийн талбай байгуулахаар гадаадын хөрөнгө оруулалттай компани 2 га газрыг эвдэгдэж байсныг Усны хэрэг эрхлэх газар, Улсын Мэргэжлийн Хяналтын газар, ТВ-9, Монголын үндэсний телевиз хамтран шалгаж үзэн үйл ажиллагааг нь зогсоов.

Цаг агаарын урьдчилсан мэдээний ерөнхий таарц төлөвлөгөөт даалгавараас 3.0-5.8 хувь, сарын урьдчилалтай мэдээний таарц 69.9 хувь буюу төлөвлөгөөт даалгавараас 7.9 хувь дээгүүр байв. Тайлангийн хугацаанд орон нутгийг цаг агаарын бодит болон прогноз зургаар үйлчилсэн ажлын гүйцэтгэл 98.8 хувьтай гарлаа.

Орон нутгийн цаг агаарын Урьдчилан мэдээлэх товчоодын нарийвчилсан урьдчилсан мэдээний таарц 92.5 хувь, хоногийн урьдчилсан мэдээний таарц 90.9 хувь, аюултай болон гамшигт үзэгдлийг урьдчилан илрүүлэлт 72.8 хувь байв.

2008 оны 07 сард олон улсын шугамд ниссэн 239, орон нутгийн 267, онцгой, тусгай үүргийн 16 нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчилсэн. Чингис хаан олон улсын нисэх буудлын 24 цагийн урьдчилсан мэдээ 124 удаа, 9 цагийн урьдчилсан мэдээ 249 удаа зохиосноос мэдээний таарц 89.4 хувь байсан нь өмнөх оны мөн үеийнхээс 6.9%-аар өссөн байна.

Районы урьдчилсан мэдээ 152, угталтын урьдчилсан мэдээ 4, Airmet мэдээ 9, нислэгийн дагуух аюултай үзэгдлийн SIGMET урьдчилсан мэдээ 31, Улаанбаатар, Сайншанд, Мөрөнгийн районы өндрийн салхины урьдчилсан мэдээ 93, Аэродромын урьдчилсан мэдээ 62-г тус тус зохиож нислэгийг үйлчилсэн ба бүх төрлийн мэдээний дундаж таарц 98.0 хувь байна. Төвөөс Тосонцэнгэл нисэх буудлын урьдчилсан мэдээ 110-ийг бичсэн, таарц 98.4% байлаа. Мөн Овоот, Оюутолгойн нисэх буудлын нислэгийн цаг агаарын мэдээний хангалтыг хариуцан ажилласан.

Нислэгт зориулсан METAR 916, SPECI-134 нийт мэдээ 1311, уур амьсгалын мэдээ 248, аюул агаар 3, CLIMAT мэдээ дамжуулж, нислэгийн аюулгүй ажиллагааг хангаж ажилласан.

Агаарын шинжилгээ. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах харуулууд 157 сорьц авч шинжилгээ хийлээ. Шинжилгээний дүнгээс үзэхэд хүхэрлэг хийн дундаж агууламж 0.003 мг/м^3 , хамгийн их нь 0.011 мг/м^3 хүрч, нийт 79 удаагийн ажиглалтаар Агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас давсан бохирдол ажиглагдаагүй байна. Азотын давхар ислийн дундаж агууламж 0.033 мг/м^3 , хамгийн их нь 0.066 мг/м^3 хүрч, нийт 78 удаагийн ажиглалтаар хүлцэх агууламжаас давсан бохирдол Баруун 4-н замын орчимд 20 удаа, 13 дугаар хорооллын орчимд 8 удаа тус тус ажиглагдсан байна.

УБ-1, УБ-2 харуулд агаар дахь гол бохирдуулагчид болох CO , SO_2 , NO_2 , PM_{10} тоосонцрыг тодорхойлох автомат багажийг шинээр суурилуулан хяналт-шинжилгээг хийж эхэллээ.

Усны шинжилгээ. Туул голын дагуух судалгаанд усны хүчилтөрөгчийн горим хэвийн, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн бохирдол илрээгүй боловч бороо орж газрын гадаргын угаагдлаар аммонийн азот, перманганатын исэлдэх чанар хромын бохирдол голын дагуудаа илэрсэн байлаа.

Хотоос доош буюу Сонгиноос Алтанбулаг сум хүртэлх хэсэгт голын усан дахь аммонийн азотын агууламж хүлцэх агууламжаас 1.3-1.7 дахин, нитритийн азотын агууламж хүлцэх агууламжаас 1.6- 5.0 дахин, перманганатын исэлдэх чанар агууламж 1.2-1.3 дахин, хромын агууламж 1.5-1.8 дахин хүлцэх агууламжаас давсан бохирдол илэрчээ. Алтанбулагийн гүүрийн мониторингийн цэгийн орчим усан дахь биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж хүлцэх агууламжаас 1.7 дахин давсан байна. Мөн Туул голын цутгал Улиастай, Сэлбэ, Дунд голын усанд аммонийн азот, перманганатын исэлдэх чанар, хромын бохирдол маш их илэрч, хүлцэх агууламжаас аммонийн азотын агууламж 2.3- 2.8 дахин, перманганатын исэлдэх чанар 1.3- 2.2 дахин, хромын агууламж 1.3- 2.8 дахин давж байлаа.

Үйлдвэрийн хаягдал усны сорьцыг Улаанбаатар хотын дүүрэг дэх 4 цэвэрлэх байгууламжийн орох, гарах нийт 8 цэгээс сорьц авч шинжилгээ хийлээ. Шинжилгээний дүнгээс үзэхэд Төв цэвэрлэх байгууламж 80%, Нисэхийн цэвэрлэх байгууламж 96%, Налайхын цэвэрлэх байгууламж 35%, Био орон сууцны цэвэрлэх байгууламж 38%-ийн цэвэршилттэй байсан байна. Энэ үед Био үйлвэрийн цэвэрлэх байгууламж ажиллахгүй байлаа.

Хөрс-цацрагийн шинжилгээ. Аэрозолын сорьц авагч багажийг ашиглалтанд оруулж аэрозолын хяналтын хэмжилтийг Улаанбаатар хотод долоо хоногт 5- 6 удаа мембран шүүлтүүрээр 24 цагийн хугацаатай сорьц авч, урт наст зохиомол цацраг идэвхт элементүүдийн нийлбэр бета идэвхжилийн хэмжээг тодорхойлж байна. Мөн цацрагийн төвшний хэмжилтийг өдөр бүр хийж байна.

Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагааг 2015 он хүртэл хөгжүүлэх Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд үүлэнд зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх зориулалт бүхий БНХАУ-д үйлдвэрлэгдсэн „RYG-1” загварын 3 ширхэг газрын генератор /шатаах төхөөрөмж/-ийг сонгосон газарт байрлуулан ажиллагаанд орууллаа. Үүнд:

- Хангайн нуруунаас эх авсан голуудын усны нөөц, урсацыг тэтгэх, түүгээр тэжээгддэг ширгэсэн нуур, цөөрмийг сэргээх зорилгоор Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг,
- Дархан цаазат, мөнх цаст Цамбагарав уулын байгаль экологийн хэвийн байдлыг хадгалах, Алтайн нуруунаас эх авч урсдаг голуудын усны ундрагыг тэтгэх зорилгоор Ховд, Баян-Өлгий аймгийн зааг дахь Цамбагарав ууланд
- Тайширын усан цахилгаан станцын усны нөөцийг тэтгэх зорилгоор Завхан аймгийн нутаг-Хангайн нуруун дахь Завхан голын эхэнд тус тус байрлууллаа.

Барилга, хот байгуулалтын салбарт:

Монголын сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлийн саналыг судалж, 2009 онд 61 байрны дээврийн их засварт 15808,6 сая төгрөг, инженерийн шугам сүлжээний засварт 21 байрын 491,05 сая төгрөг, 60 лифтийг шинэчлэхэд 1983 сая төгрөгийг 2009 оны Улсын төсвийн төлөвлөгөөнд тусгуулахаар төсвийн хүрээний мэдэгдэлд оруулах ажлыг зохион байгуулав.

Геодези, зураг зүйн салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг, Газрын үнэлгээний тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгүүдийг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулж, ажлын төлөвлөгөөг батлуулав.

Барилга, хот байгуулалтын сайдын 2008 оны 07 дугаар сарын 24-ний 115 тоот тушаалаар “Барилгын мэдээллийн санг бүрдүүлэн, түүний байнгын ажиллагааг эрхлэх журам”-ыг батлуулав.

Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар Нийслэл хотод шинээр баригдсан 2 барилга дээр барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комиссыг томилон ажиллуулав.

Улаанбаатар хотын механик ачааллыг сааруулах, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан Төвийн бүсийн тулгуур төв Дархан хотын хөгжлийг тодорхойлох ажлын хүрээнд “Дархан-500” хөтөлбөрийн төслийг боловсруулав.

БНТУ-ын Нийтийн аж ахуй, нутагшилт суурьшлын яамтай байгуулсан хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлэх санамж бичгийн хүрээнд Монголын барилгын салбарын ажилчид тус улсын барилгын салбарын туршлагаас судлах 2007-2008 онд хэрэгжих хөтөлбөр БНТУ-ын холбогдох байгууллагуудаар батлагдсан бөгөөд Туркийн талаас ирүүлэх албан ёсны урилгыг хүлээж байна. 2008 оны 07 дугаар сарын 08 -нд БНСУ-ын Газар, тээвэр, далайн хэрэг эрхлэх яамны Барилга, Усны нөөцийн асуудал эрхэлсэн дэд сайд Вон Жин Вон тэргүүтэй төлөөлөгчид Барилга, хот байгуулалтын сайдтай ажил хэргийн уулзалт зохион байгуулж, 2 яам хоорондын холбогдох асуудлыг багтаасан санамж бичиг байгуулахаар тохиролцож Солонгосын талаас санамж бичгийн төсөл ирүүлэхээр болсон. Уг санамж бичигт хөрсний ус, гүний усыг хамгаалах асуудал болон барилгын салбарын боловсон хүчин бэлтгэх асуудлыг хөндөх юм.

Зам, тээвэр, аялал жуулчлалын салбарт:

Аялал жуулчлалын салбар дахь гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Болгар Улсын Засгийн газар хоорондын Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг байгуулах тухай асуудлыг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Уг асуудлыг Засгийн газрын 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж санамж бичиг байгуулах нь зүйтэй гэж үзсэн тэмдэглэл гарч Ерөнхийлөгч Н.Энхбаярын БНБУ-д хийх айлчлалын үеэр гарын үсэг зурахад бэлэн болгоод байна.

Манай улсад 2008 оны эхний 6 сарын байдлаар 190316 гадаадын жуулчин ирсэн нь 2007 оны мөн үеийнхээс 16.8 хувь буюу 27442 жуулчнаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Жуулчдын тооны өсөлтийг бүс нутгаар нь ангилан үзвэл Африк -11.9 %-иар буурч, Америк 18.6 %, Ази 16.8 %, Австрали 13.9 %, Европ тивээс ирэгсдийн тоо 16.7 %-р тус тус өссөн үзүүлэлттэй байна. Голлох зах зээлийн орноор авч үзвэл ОХУ (19.3 % буюу 8007 жуулчнаар), БНСУ (25.5 % буюу 2978 жуулчнаар), Герман (17.0 % буюу 327 жуулчнаар), АНУ (16.0 % буюу 619 жуулчнаар) улсаас ирж буй жуулчдын тоо өндөр өсөлттэй байна.

Энэ оны 7 дугаар сарын 1-нд онц байдал тогтоосонтой холбогдуулан Монгол Улсын гадаад нэр хүндийг өсгөх, гадаадын байгууллага, иргэдэд үнэн зөв мэдээлэл өгөх, үүссэн сөрөг үр дагаварыг шуурхай арилгах зорилгоор ГХЯ-ны хэвлэл, мэдээллийн хэлтэстэй хамтран Монгол Улсад байнгын болон түр бүртгэлтэй сурвалжлагч нарыг оролцуулсан хэвлэлийн бага хурал зохион байгууллаа. Түүнчилэн, 7 дугаар сарын 15-нд Гадаад сурталчилгаа, соёлын харилцааг зохицуулах үндэсний зөвлөлийн хуралд оролцож, Монгол орны эерэг гадаад сурталчилгааг өргөжүүлэх, Японы жуулчдыг визгүй аялуулах зэрэг асуудлаар санал солилцов.

Улаанбаатар-Лүн чиглэлийн 106.2км хатуу хучилттай авто замын шинэчлэлтийн барилгын ажлын явцыг сайжруулах, шаардлагатай арга хэмжээг цаг тухай бүрд нь авч гэрээт хугацаанд ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлж ажиллах ажлын хэсгийг Сайдын тушаалаар байгуулав.

“МИАТ” ХК-ийн гуравдагч улсад бүртгэлтэй Боинг-737W агаарын хөлгийг тохиролцсон нислэгийн шугаманд ашиглах талаар БНСУ-ын талаас ирүүлсэн Харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг судлан үзэж, саналаа танилцуулах болон ОХУ, Япон, Турк, Казахстан улсуудын Иргэний нисэхийн удирдах байгууллагатай агаарын харилцааны асуудлаар 2008 онд төлөвлөсөн уулзалт хэлэлцээ хийх ажлыг зохион байгуулах, агаарын тээврийн компаниудиас томилогдсон нислэгийн шугаманд нислэг гүйцэтгэх эсэх болон цаашдын төлөвлөлтийн талаар санал авч судлаж танилцуулах чиглэлийг Иргэний нисэхийн ерөнхий газарт өгөв.

БНСУ-ын Газар, тээвэр, далайн хэрэг эрхэлсэн яаманд “МИАТ” ХК-ийн 7-8 сард гүйцэтгэхээр төлөвлөсөн долоо хоногийн 9 удаагийн нэмэлт нислэгийн асуудлыг шийдвэрлэж өгөх хүсэлтийг гаргасан бөгөөд асуудлыг Гадаад хэргийн яаманд танилцуулж БНСУ-ын талд нот бичгээр хүргүүлэв.

“МИАТ” ХК-иас дотоодын нислэгт ашиглах 2 агаарын хөлгийг худалдан авах/түрээслэх асуудлыг зохицуулан шийдвэрлэхээр ЗТАЖЯ, ХЗДХЯ, ТӨХ, ИНЕГ, “МИАТ” ХК-ийн төлөөллийг оролцуулсан хамтарсан ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсэг зах зээл дээрх агаарын хөлгийн талаар судалгааг хийж байна.

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар байгуулагдсан Замын-Үүд дахь ачаа шилжүүлэн ачих ангийн байгууламж, үйл ажиллагааг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанид хүлээлцүүлэх комиссыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд, Төрийн өмчийн хорооны даргын 2008 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 117/122 тоот тушаалаар байгуулсан.

“Бээжин 2008” шуудангийн маркийн анхны өдрийн нээлтийг 2008.07.17-нд Монголын Үндсэний олимпын хороонд хийлээ. Тус нээлтэнд ЗТАЖЯ, МҮОХ, “Монголшуудан” ХХК-ний албаны хүмүүс оролцсон бөгөөд маркийн дээжээс олимпын эрх авсан баг тамирчидыг дэмжиж 200 сери маркийг гардуулав.

Нийслэлийн Захирагчийн ажлын албаны Аялал жуулчлалын хэлтсээс санаачлан “Дээлтэй Монгол” аялал жуулчлал, соёлын арга хэмжээг 7-р сарын 8-ны өдөр Сүхбаатарын талбайд 2 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Улсын чанартай авто зам, замын байгууламжуудыг арчилах, засварлах ажлын 2008 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдлыг газар дээр нь үзэж шалгах, ажлыг эрчимжүүлэх зорилгоор ажлын хэсгүүд томилогдон Хэнтий аймгийн “Харгуй” ХК, “Улаанбаатар АЗЗА”ХК, “Өвөрхангай АЗЗА”ХК, “Хархорин АЗЗА”ХК, “Архангай АЗЗА” ХК, “Булган АЗЗА”ХК, “Хөвсгөл АЗЗА”ХК, “Хөвсгөл зам” ХХК, “Дархан АЗЗА”ХК, “Орхон АЗЗА”ХК, Баянхонгор аймгийн “Номгонхайрхан” ХХК, “Ховд АЗЗА” ХК, Баян-Өлгий аймгийн “Жол” ХК, “Увс АЗЗА”ХК, “Завхан АЗЗА” ХК-иудын хариуцсан улсын чанартай авто замуудыг үзэж шалгаж зохих технологийн заавар, зөвлөгөө өгч, шаардлага тавин ажилласан төдийгүй улсын төсвийн хөрөнгөөр Хүй долоон худаг дахь хурдан морины уралдааны 30км авто замыг засаж сайжруулав.

Засгийн газраас шийдвэрлэсний дагуу улсын төсвийн хөрөнгөөр Улаанбаатар-Лүн чиглэлийн авто замаас Хүй долоон худаг дахь авто машины зогсоол хүртэлх 2.3 км авто замыг “Очир төв” ХХК-тай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэв.

Улсын чанартай авто зам, замын байгууламжуудад 2008 оны 6 дугаар сарын сүүлч, 7 дугаар сард хүчтэй аадар, бороо орсны улмаас үүссэн гэнэтийн эвдрэлийг газар дээр нь бодит байдлаар тогтоож хэмжилт хийж, төсвийг хянах зорилгоор Авто замын хяналт, судалгааны төвтэй хамтарсан ажлын хэсгүүд тухайн орон нутгийн авто замын засвар, арчлалтыг хариуцсан байгууллагуудтай хамтарч хэмжилтийг бодит байдлаар нь үзэж шалгав.

“Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн NP-1, AR-2 багцын гүйцэтгэгчээр шалгарсан “Shengli Engineering” компаний тоног төхөөрөмж, бараа материалыг гааль болон НӨАТ-аас чөлөөлүүлэх асуудлыг Сангийн яаманд хүргүүлэн шийдвэрлүүлэв.

БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Чойр Сайншанд чиглэлийн 176 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгч “Hanshin Engineering” компаний бараа материалыг гааль болон НӨАТ-аас чөлөөлүүлэх асуудлаар байгуулагдсан Сангийн яамтай хамтарсан ажлын хэсэг Чойр-Сайншанд чиглэлийн зам барилгын ажлын явцыг газар дээр нь үзэж танилцав.

Олон улсын болон улсын чанартай авто замын төлбөр хураах цэгээс 382.2 сая төгрөгийн орлого орж, үйл ажиллагааны урсгал зардалд 117.3 сая төгрөгийг, өөрийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтэд 89.7 сая төгрөгийн, нийт 242.8 сая төгрөгийн санхүүжилт, аялал жуулчлалын санд 110.1 сая төгрөгийн орлого орж, төсөл, арга хэмжээний зардалд 84.1 сая төгрөгийн санхүүжилт хийгдэв.

Түлш, эрчим хүчний салбарт:

Засгийн газрын 2008 оны 233 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Түлш, эрчим хүчний сайд, Төрийн өмчийн хорооны даргын хамтарсан 107/123 дугаар тушаалаар “төрийн өмчит хувьцаат компаниудыг шинээр байгуулах, үйл ажиллагааны дүрмийг боловсруулах, эд хөрөнгийн төрийн өмчид бүртгэх” ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Даланзадгадын дулааны цахилгаан станцыг БНСУ-ын техник технологиор барьж байгуулсантай холбогдуулан тус улсын судалгааны багууд ирж боловсон хүчнийг дадлагажуулж, чадваржуулах, техник технологийн чиглэлээр ажиллаж байна.

Эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, зуух даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох урьдчилсан дүгнэлт гаргах комиссын хурлыг 2008 оны 7 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж 18 компанийн асуудлыг авч хэлэлцсэнээс комиссын хуралдааны шийдвэрийг үндэслэн Түлш, эрчим хүчний сайдын 2008 оны 108 дугаар тушаалаар 8 компанийн эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, зуух даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 7 компанид нэмэлт ажилбар олгов.

Тайширын усан цахилгаан станцын барилга угсралтын ажил дууссантай холбогдуулан тус станцад ажлын комисс ажилласнаас улсын комисст хүлээлгэн өгөх нь зүйтэй гэсэн дүгнэлтийг гаргав. Дөргөний усан цахилгаан станц хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулан компаний дүрмийг баталж, гүйцэтгэх захирлыг томилон ажиллуулж байна.

Түлш, эрчим хүчний салбарт 2008 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсны дагуу эхний 7 сарын байдлаар нийт 17,699,2 сая төгрөгийн урьдчилгаа болон үе шатны ажлын гүйцэтгэлийн санхүүжүүлэв.

Дизель станцаар эрчим хүч үйлдвэрлэн хэрэглэгчдийг хангадаг Говь-Алтай аймгийн эрчим хүчний үйлдвэрт 236,9 сая, Завхан аймгийн Улиастайн эрчим хүчний үйлдвэрт 55,0 сая төгрөгийг дизелийн түлшний санхүүжилтэд тус тус олгов.

Түүнчлэн эрчим хүчний алдагдлын санхүүжилт авдаг Баруун бүсийн эрчим хүчний систем компанид 300,0 сая, Налайхын дулааны станцад 55,0 сая төгрөгийн санхүүжилтийг, эрчим хүчний үйлдвэрүүдэд 649,9 сая төгрөгийн урсгал зардлын санхүүжилтийг тус тус олгов.

Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны зардалд эхний хагас жилийн байдлаар нийт 237.8 сая төгрөгийн гүйцэтгэлийг санхүүжүүлээд байна.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт:

“Улсын сайн малчин, Тэргүүний тариаланч хамт олон, Тэргүүний тариаланч шалгаруулах журамд өөрчлөлт оруулах тухай” , Махны нөөц бүрдүүлэх зарим арга хэмжээний тухай”, “Малын гоц халдварт өвчний оношийг баталгаажуулах, хорио цээр, хязгаарлалтын бүс тогтоох, уг бүсэд үйл ажиллагаа явуулах журам”, “2008-2009 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” боллон хаврын тариалалтын дүнгийн талаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

“Эрчимжсэн аргаар хонь үхрийн мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд махны чиглэлийн үхэр хонь үржүүлэх технологийн сургалт, үзүүлэх сургуулийг Архангай, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ аймгийн 56 иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцуулан Сэлэнгэ аймгийн Хушаат сумын “Орхон Түшээ” ХХК-ийг түшиглэн зохион байгуулав.

Төв, Баянхонгор, Говь-Алтай аймгийн зарим сумын бэлчээрт тархсан оготно, царцаатай тэмцэж байгаа ажлын явц, үр дүнтэй газар дээр нь танилцах, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, Өвөрхангай аймгийн баруун талын зарим суманд тархсан оготны тархалт, хөнөөлийн байдлыг судлаж цаашид авах арга хэмжээг төлөвлөх ажлаар томилолтоор дээрх аймгуудын холбогдох сумдад ажиллав.

“Атрын гурав дахь аян”-тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд 1000тн азотын бордоо, 100ш нийлэг хальсан хүлэмж дуслын усалгааны төхөөрөмжийн хамт, “Ногоон хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд 43 ш нийлэг хальсан хүлэмж дуслын усалгааны төхөөрөмжийн хамт хүлээн авч, захиалгын дагуу хуваарилан олгоод байна.

Улсын ургацын комиссын хуралдааныг зохион байгуулж, уг хурлын тэмдэглэл, Ургацын комиссын даргын 01 тоот албан даалгаврыг гишүүдэд хүргүүлэв. Ургацын комиссын хуралдааны шийдвэрийн дагуу ургац тээвэрт ашиглах зам гүүрийн эвдрэл,

гэмтлийг шалгаж тодруулах ажлын хэсгийг орон нутагт ажиллуулах тухай, түүнчлэн Сэлэнгэ аймгийн Хушаат сумын нутагт орших Орхон гол дээр шинээр төмөр бетон гүүр барих зураг төслийг боловсруулах тухай албан тоотыг Зам тээвэр, аялал жуулчлалын яаманд тус тус хүргүүлэв.

Малын эмийн зөвлөлийн 4-р хуралдааныг зохион байгуулж, Мал эмнэлгийн хүрээлэнгээс ирүүлсэн 17 стандартын төсөл, үйлдвэрлэх, шалгах, хэрэглэх зааврын хамт Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн техникийн хороонд уламжилав.

Хүнсний үнийн хөөрөгдөлд авах арга хэмжээний хүрээнд НҮ-ний ХХААБ-тай хамтран салбар хоорондын ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Уг ажлын хүрээнд “Хүнсний үнийн хөөрөгдөлд өртсөн хүн амд ХАА-н үйлдвэрлэлийн орцуудыг нийлүүлэх” төсөл болон дунд, урт хугацааны улсын хэрэгцээ, хүнсний үнийн хөөрөгдөлд авах арга хэмжээг тодорхойлох асуудлаар НҮ-ний ХХААБ-ын олон улсын зөвлөлтэй хамтран ажиллаж байна. Мөн нийгэмд үзүүлэх нөлөөг судлах үүрэг бүхий ХАА-н үйлдвэрлэлийн дэд хэсгүүдийн хамтарсан хурлыг зохион байгуулав.

Гадаад бодлогын чиглэлээр:

ПЕКК-ийн Байнгын Хорооны хуралд манай төлөөлөгч оролцож, Монгол Улс жинхэнэ гишүүн болов. Монгол Улсын Ерөнхийлөгч 6 дугаар сарын 30 –нд Кувейтын Эмирийн Монголд хийх хувийн айлчлалын бэлтгэлийг базаахаар ирсэн Эмирийн Хэрэг эрхлэх сайд Шейх Нассер-ыг хүлээн авсан уулзаж, хоёр талын харилцааны зарим асуудлаар санал солилцов.

Бээжинд суугаа Канадын Элчин сайд Ж. Райт 6 дугаар сарын 24 – 25 –ны өдрүүдэд ирж ажиллав. Ерөнхий сайд С.Баяр Гадаад хэргийн сайд С.Оюун нар Элчин сайдыг 24, 25 –ны өдрүүдэд хүлээн авч уулзав. Канадын Засгийн газар Монголд Худалдааны төлөөлөгчийн газраа нээх болж, Монголд сууж ажиллах Элчин сайдыг томилсон талаар Элчин сайд мэдээлэв.

Данийн угсаа залгамжлах Ханхүү Фредерикийн 8 дугаар сарын 20-22-нд Монгол Улсад хийх айлчлалын бэлтгэлийг үргэлжлүүлэн хийж, энэ асуудлаар 7 дугаар сарын 17-18-нд Улаанбаатарт ажилласан Бээжин дэх Данийн ЭСЯ-ны төлөөлөгчидтэй уулзан, Ханхүүг дагаж ирэх сэтгүүлчид болон бизнесийн хэсгийн хөтөлбөр, Монгол-Данийн нийгэмлэг, Хэвлэлийн хүрээлэнд зочлох, Боловсролын их сургуулийн Хүндэт доктор цол олгох асуудлаар санал солилцов.

ХБНГУ-ын Ерөнхийлөгч Х.Көлөрийн 9 дүгээр сарын 4-6-нд Монгол Улсад хийх төрийн айлчлалын бэлтгэл ажлын хүрээнд Германы ГХЯ-ны Ёслолын газрын дарга, Элчин сайд Штек тэргүүтэй төлөөлөгчид 7 дугаар сарын 1-4-нд Улаанбаатарт ажиллав. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орсон ЕТГ-ын Азийн хэлтсийн дарга Шмидтэй айлчлалын агуулга, харилцааны байдлын талаар ярилцав.

Франц Улс 7 дугаар сарын 1-нээс Европын Холбоог даргалах болсонтой холбогдуулан ГХЯ-ны ТНБД Д.Цогтбаатар Францын Элчин сайд П.Крисманыг 6 дугаар сарын 24-нд хүлээн авч уулзаж, Монгол, Европын Холбооны хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлэх, цаашид анхаарах чиглэлүүдийн талаар ярилцан санал солилцов.

Булган аймагтай шууд хамтын ажиллагаа тогтоон 70 жилийн ойн баярын үйл ажиллагаанд оролцсон Унгарын Чонград мужийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга М.Анна, Унгарын Улсын хурлын гишүүн, Гадаад хэргийн БХ-ны дэд дарга К.Йожеф нарыг УИХ-ын дарга Д. Лүндээжанцан 7 дугаар сарын 16-нд хүлээн авч уулзаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Монгол Улсын Засгийн газар 2008 оны 6 дугаар сарын 25-ны өдөр “Эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг баталсныг ГХЯ-ны 2008 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн А/08-1046 тоот ноот бичгээр БНТУ-ын ЭСЯ-нд мэдэгдэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Кувейт Улсад хийсэн айлчлалын үеэр байгуулсан “Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар, Кувейт Улсын газрын тосны корпораци хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг” хүчин төгөлдөр болсон

тухай ГХЯ-ны 2008.06.16-ны өдрийн А/08-924 тоот ноот бичгийг мөн өдрийн 07/2559 тоот албан бичигт хавсарган Бээжин дэх ЭСЯ-нд хүргүүлэв. Мөн дээрх ноотны хуулбар, санамж бичгийг соёрхон баталсан тухай кувейтын талын ноот бичгийн хуулбар зэргийг тус тус ГХЯ-ны 07/2558 тоот албан бичигт хавсарган АМГТХЭГ-т хүргүүлэв.

Дархан хотын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт орших хуучнаар зөвлөлтийн эмнэлгийн гаражийн барилгыг Оросын Холбооны Улсад өмчлүүлэх эрх, түүнийг "Госзагрансобственность" байгууллагаас ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дэмжлэг хүсэх тухай ОХУ-ын ЭСЯ-ны 2008 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 106 тоот ноот бичгийн хуулбарыг хавсралтын хамт Үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт албан бичгээр хүргүүлэв.

Дамжин өнгөрөх тээврийн тухай хэлэлцээрийн хавсралтуудыг боловсруулах гурван талын шинжээчдийн уулзалтыг 7 дугаар сарын 3-ны өдөр Москва хотноо зохион байгуулах тухай ОХУ-ын Тээврийн яамнаас ирүүлсэн саналыг хятадын тал хүлээж аваагүйтэй холбогдуулан уулзалтыг хойшлуулахаар болов. Шинжээчдийн уулзалтыг хойшлуулах, 2008 оны 9, 10 дугаар сард Москва хотноо зохион байгуулах саналыг ОХУ-ын Тээврийн яамнаас ирүүлснийг ажлын хэсгийн гишүүд, НҮБ-ын ХХБХ, Женев дэх БТГ-т мэдэгдэв. Уг уулзалтад оролцох монголын талын төлөөлөгчдийн нэрсийг холбогдох байгууллагуудаас авахаар албан тоот илгээсэн бөгөөд USAID-тэй хамтран ажлын хэсгийн боловсруулсан хэлэлцээр, түүний хавсралтуудын төслийг НҮБ-ын ХХБХ-д хүргүүлэв.

Батлан хамгаалах чиглэлээр:

Дайчилгааны тухай Монгол Улсын хуулийн дагуу дайчилгааны 1, 2 дугаар зэргийн бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний цэргийн бэлтгэл сургалтуудыг зохион байгуулав. "Хааны эрэлд" хээрийн сургуульд гадаад орнуудаас ажиглагч нарыг оролцуулж хөтөлбөр, урилга илгээх ажлыг зохион байгууллаа.

БНАСАУ-ын төлөөлөгчдийн айлчлалыг 2008 оны 07 дугаар сарын 16-19-ны өдрүүдэд зохион байгуулсан. Зэвсэгт хүчний 123 дугаар ангитай дайчилгаатай КШХС-ийг "МБХ-г дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулж, уулархаг районд жижиг бүлгийн байлдааны ажиллагааг зохион байгуулж явуулах нь" сэдвээр удирдан явуулав.

Байлдааны жижүүрлэлтийн анги, салбаруудын хүч хэрэгслээр энэ сард 7797 агаарын хөлгийн нислэгт радиолокацийн станцын болон диспетчерийн хяналт тавьснаас 6814 нь олон улсын, 889 нь орон нутгийн, 31 нь тусгай үүргийн, 63 нь хилийн гаднах нислэг байв. Нислэгийн горим, маршрутын зөрчил илрээгүй.

ЗХЖШ-ын даргын өгсөн үүргийн дагуу Зэвсэгт хүчний сургалтын тогтолцоог өөрчлөх саналыг боловсруулан ЗХЖШ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсний гадна "Зэвсэгт хүчний 2008-2009 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөө", "2008-2009 оны сургуулийн жилийн цэргийн сургалтын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах заавар"-ын төслийг эхний хувилбараар боловсрууллаа.

"Иракийн эрх чөлөө" олон улсын цэргийн ажиллагаанд оролцож буй цэргийн багийн IX ээлжийн бүрэлдэхүүнийг Х ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүнээр солих ажлыг осол авааргүй, амжилттай зохион байгууллаа. Тус ажиллагаанд оролцсон IX ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн цэргийн дээд командлалаас өгсөн үүрэг даалгаврыг амжилттай гүйцэтгээд эх орондоо хүрэлцэн ирлээ.

Сиерра Леон Улсад НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй Y ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүн болон Баруун Сахар, Конго, Судан, Этиопид НҮБ-ын явуулж буй энхийг сахиулах ажиллагаанд Зэвсэгт хүчний 8 офицер цэргийн ажиглагчийн үүргээ хэвийн гүйцэтгэж байна. Гүржид НҮБ-ын явуулж буй энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс цэргийн ажиглагчийн үүрэг гүйцэтгэж байсан 1 офицер үүргээ амжилттай гүйцэтгээд эх орондоо ирлээ.

Сиерра Леон Улсад НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх YI ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүний ажиллагааны өмнөх сургалтыг Таван толгой дахь Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд явуулж, бэлтгэлийг нь хангуулан илгээхэд бэлэн болголоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 153 дугаар зарлигаар батлагдсан "Цэргийн анги, байгууллагыг аж ахуйн ажилд оролцуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт, ЗХЖШ-аас "Жуулчин-Монгол наадам" ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Улаанбаатар цэргийн хүрээний 10 анги, байгууллагаас офицер 9, ахлагч 24, хугацаат цэргийн албан хаагч 323, ажилчин албан хаагч 15, нийт 371 хүн Төв аймгийн "Өндөр дов"-ын районд байрлан "Чингэсийн баатрууд" үзүүлбэрт оролцож байна.

Хууль зүйн чиглэлээр:

Нисдэг тэрэг худалдан авах үнийн тухай, Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөр батлах тухай, Газрын тос боловсруулах үндэсний үйлдвэр байгуулах төслийг дэмжих тухай, Тамирчдад мөнгөн урамшуулал олгох тухай, Монгол Улсын музейг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай, Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай, Улсын нөөцөд өвс, тэжээлийг бүрдүүлэх тухай, Хөрөнгө гаргах тухай зэрэг Засгийн газрын 38 шийдвэрийн төслийг хянаж санал өгсөн.

Тайлангийн хугацаанд албан болон хувийн хэргээр түр буюу удаан хугацаагаар ирэх гадаадын иргэдэд холбогдох төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хүсэлтийг үндэслэн орох 2669, орох гарах 202, олон удаагийн 81 нийт 2977 гадаадын иргэнд олгох визийн зөвшөөрлийг Гадаад хэргийн яамны консулын газарт өгч, гарах-орох 972, гарах 1555, олон удаагийн 3237 виз олгосон.

Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, бүртгэл, хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн болон визийн хугацаа хэтрүүлсэн зэрэг зөрчил гаргасан гадаадын 26 орны 438 иргэнд Захиргааны хариуцлагын тухай хуульд заасны дагуу 77 сая 600 мянган төгрөгийн мөнгөн торгууль ногдуулсан байна.

Гадаадын орнуудаас урьсан иргэнээ зохих хугацаанд бүртгүүлээгүй, хууль бусаар хөдөлмөр эрхлүүлсэн, визийн хугацааг хэтрүүлсэн, нуун далдалсан зэрэг зөрчлийн улмаас 72 байгууллага, аж ахуйн нэгжид нийт 53 сая 200 мянган төгрөгийн мөнгөн торгууль ногдуулан улсын орлогод оруулсан байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР